



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/404

Есөнбулаг сум

Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 6.3, 6.4, 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.5.2 дахь заалт, Монгол улсын засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт шүлхий (SAT-1) өвчин бүртгэгдсэн Баян-Өлгий, Ховд аймгуудаас амьд мал, амьтан аймгийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхийг 2026 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглосугай.

2.Аймаг дотроо мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, мал эмнэлгийн цахим гэрчилгээг үндэслэн хийхийг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), сумдын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсүгэй.

3.Мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаас шилжин ирэх мал, амьтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, мал эмнэлгийн цахим гэрчилгээ, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн хүлээн авч, нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсүгэй.

4.Мал, амьтны тээвэрлэлт, тууварлалтын хөдөлгөөнд байнгын хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

6.Аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/373 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

